



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/185

Чингис хот

Хөрөнгө зарлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Бор-Өндөр, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сум, Хэрлэнбаян-Улаан тосгонд коронавируст халдвар /ковид-19/-ын сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан хавьтлыг илрүүлж шинжилгээ эваж ажлыг зохион байгуулахад зориулж сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг хавсралтаар баталсугай.

2. Халдвар хамгааллын дэглэм тогтоох, сэжигтэй тохиолдлын хавьтлыг илрүүлэх, тархах эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ажиллахад шаардагдах 19.000.000 /арван есөн сая/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 19 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



1. Бор-Өндөр сум 15.000.000
2. Цэнхэрмандал 2.000.000
3. Дэлгэрхаан 1.000.000
4. Хэрлэнбаян-Улаан 1.000.000